



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/084/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2025.02.10	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер М.Алтантуяа Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Азбаяр Утас: 99061429 Цахим хаяг: Azbayarb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Төлбөрийн акт.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 2/56

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Боловсролын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 7,710,692.6 мянган төгрөгийн төсөв батлагдсаныг бүрэн санхүүжүүлж, гүйцэтгэлээр 7,692,693.2 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 17,999.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Боловсрол шинжлэх ухааны газрын 2024.07.09-ний өдрийн Б/42 "Урамшуулал олгох тухай" тушаалаар "Өөрчлөлтгүй" дүгнэлт авсан Төсвийн шууд захирагч нарт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох шийдвэр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр

ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРЛҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ





הנדחת פסק הדין

בשם הדין, אני מורה על פיקוח נפש, על מנת להבטיח את בטיחות הילד, עד להחלטת בית דין.

הפיקוח יבוצע על ידי הוראת הילד למשק ביתו, תחת אחריות ההורה, עד להחלטת בית דין.

הפיקוח יבוצע עד לתאריך 06.07.2024, או עד להחלטת בית דין, whichever is later.

הפיקוח יבוצע עד לתאריך 06.07.2024, או עד להחלטת בית דין, whichever is later.

הפיקוח יבוצע עד לתאריך 06.07.2024, או עד להחלטת בית דין, whichever is later.

הפיקוח יבוצע עד לתאריך 06.07.2024, או עד להחלטת בית דין, whichever is later.

הפיקוח יבוצע עד לתאריך 06.07.2024, או עד להחלטת בית דין, whichever is later.

הפיקוח יבוצע עד לתאריך 06.07.2024, או עד להחלטת בית דין, whichever is later.

הפיקוח יבוצע עד לתאריך 06.07.2024, או עד להחלטת בית דין, whichever is later.

הפיקוח יבוצע עד לתאריך 06.07.2024, או עד להחלטת בית דין, whichever is later.

הפיקוח יבוצע עד לתאריך 06.07.2024, או עד להחלטת בית דין, whichever is later.

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>182,000,152.00</u>	<u>73,048,485.64</u>
33	АВЛАГА	1,109,656.68	4,917,524.64
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	149,863.00	4,917,524.64
335	Бусад авлага	959,793.68	0.00
3351	Байгууллагаас авах авлага	359,793.68	0.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	600,000.00	0.00
34	УРЬДЧИЛГАА	1,571.00	0.00
3471	Урьдчилгаа тооцоо	1,571.00	0.00
34713	Цалингийн урьдчилгаа	1,571.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	180,888,924.32	68,130,961.00
351	Түүхий эд материал	135,000.00	135,000.00
35110	Тусгай зориулалттай материал	135,000.00	135,000.00
354	Хангамжийн материал	180,753,924.32	67,995,961.00
35410	Бичиг хэргийн материал	8,875,610.00	2,517,510.00
35420	Аж ахуйн материал	167,735,678.32	63,550,815.00
35430	Сэлбэг хэрэгсэл	885,000.00	0.00
35440	Түлш, шатах тослох материал	210,000.00	0.00
35450	Барилгын засварын материал	1,120,000.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	1,927,636.00	1,927,636.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>817,104,717.82</u>	<u>791,772,064.73</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	817,104,717.82	791,772,064.73
392	Биет хөрөнгө	539,719,673.13	516,468,206.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	507,858,350.00	507,858,350.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(79,862,038.27)	(88,658,827.51)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,600,000.00	33,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(12,600,000.00)	(16,800,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	141,660,336.90	167,225,481.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	(58,210,315.72)	(96,872,001.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,588,847.47	18,688,847.47
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,175,409.75)	(11,433,546.61)
39217	Ном	2,859,902.50	2,859,902.50
393	Биет бус хөрөнгө	277,385,044.69	275,303,858.48
39301	Програм хангамж	16,104,000.00	16,104,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(14,676,083.31)	(15,757,333.52)
39303	Бусад биет бус хөрөнгө	277,957,000.00	277,957,000.00

Баянхонгор аймгийн Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,999,872.00)	(2,999,808.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>999,104,869.82</u>	<u>864,820,550.37</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>350,527.80</u>	<u>0.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	350,527.80	0.00
413	Өглөг	350,527.80	0.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	350,527.80	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,395,000.00	0.00
4136	Бусад өглөг	(1,395,000.00)	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	(1,395,000.00)	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>998,754,342.02</u>	<u>864,820,550.37</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	998,754,342.02	864,820,550.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	483,939,977.83	483,939,977.83
51101	Өмч: - төрийн	483,939,977.83	483,939,977.83
512	Хуримтлагдсан үр дүн	496,991,647.05	363,057,855.40
51210	Өмнөх үеийн үр дүн	518,635,322.30	496,991,647.05
51220	Тайлант үеийн үр дүн	(21,643,675.25)	(133,933,791.65)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	17,822,717.14	17,822,717.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>999,104,869.82</u>	<u>864,820,550.37</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,786,484,343.20	7,837,699,421.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	139,474,121.20	23,165,245.00
120	Нийтлэг татварын бус орлого	139,474,121.20	23,165,245.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	139,474,121.20	23,165,245.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	139,474,121.20	23,165,245.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,647,010,222.00	7,814,534,176.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,559,752,400.00	7,710,692,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,559,752,400.00	7,710,692,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	87,257,822.00	103,841,576.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,711,260.00	66,349,312.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	36,785,312.00	37,492,264.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	761,250.00	-

Баянхонгор аймгийн Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,807,540,960.82	7,971,633,213.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,807,540,960.82	7,971,633,213.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	910,186,849.48	1,117,675,178.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	485,300,748.95	681,759,692.68
210101	Үндсэн цалин	297,297,457.00	390,083,606.68
210102	Нэмэгдэл	93,361,262.95	177,828,586.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	78,240,000.00	48,500,000.00
210104	Урамшуулал	16,402,029.00	65,347,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,330,315.75	86,562,795.06
210201	Тэтгэврийн даатгал	41,718,064.11	58,223,158.93
210202	Тэтгэмжийн даатгал	4,908,007.51	6,849,783.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,926,406.06	3,424,891.89
210204	Ажилгүйдлийн даатгал	979,801.45	3,612,991.89
210205	Эрүүл мэндийн даатгал	9,798,036.62	14,451,968.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,723,768.48	78,925,145.72
210301	Гэрэл, цахилгаан	2,244,366.48	3,203,194.17
210302	Түлш, халаалт	59,275,406.00	73,973,897.55
210303	Цэвэр, бохир ус	1,203,996.00	1,748,054.00
2104	Хангамж, бараа материалын зардал	188,285,584.48	140,350,301.32
210401	Бичиг хэрэг	10,212,900.00	10,391,800.00
210402	Тээвэр, шатахуун	13,042,960.00	17,239,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,930,060.00	556,600.00
210404	Ном, хэвлэл	38,000.00	38,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	650,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,488,000.00	111,474,901.32
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	159,973,664.48	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,790,400.00	1,120,000.00
210604	Урсгал засвар	1,790,400.00	1,120,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	5,000,000.00
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,068,072.00	0.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	62,334,812.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	179,300.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	85,960.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	0.00
210807	Газрын төлбөр	185,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,687,959.82	123,957,244.09

Баянхонгор аймгийн Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,670,500.00	10,309,030.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,793,400.00	58,650,416.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,224,059.82	54,997,798.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,897,354,111.34	6,853,958,034.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,826,176,597.00	6,835,926,389.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,546,654,033.00	1,511,704,613.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,278,969,764.00	5,272,671,020.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	552,800.00	51,550,756.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	71,177,514.34	18,031,645.28
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	71,177,514.34	18,031,645.28
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(21,056,617.62)</u>	<u>(133,933,791.65)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	587,057.63	0.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	587,057.63	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(587,057.63)	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(21,643,675.25)</u>	<u>(133,933,791.65)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	483,939,977.83	17,822,717.14	518,875,322.30	0.00	1,020,638,017.27
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-240,000.00	0.00	-240,000.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	483,939,977.83	17,822,717.14	518,635,322.30	0.00	1,020,398,017.27
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00

Баянхонгор аймгийн Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-21,643,675.25	0.00	-21,643,675.25
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	483,939,977.83	17,822,717.14	496,991,647.05	0.00	998,754,342.02
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	483,939,977.83	17,822,717.14	496,991,647.05	0.00	998,754,342.02
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	483,939,977.83	17,822,717.14	496,991,647.05	0.00	998,754,342.02
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-133,933,791.65	0.00	-133,933,791.65
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	483,939,977.83	17,822,717.14	363,057,855.40	0.00	864,820,550.37

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		/төгрөгөөр/	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,710,692,600.00	7,693,293,202.72	17,399,397.28	99.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,710,692,600.00	7,693,293,202.72	17,399,397.28	99.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	857,375,400.00	857,366,813.72	8,586.28	100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	649,350,600.00	649,350,600.00	-	100.00
210101	Үндсэн цалин	365,069,400.00	322,962,001.00	42,107,399.00	88.47
210102	Нэмэгдэл	232,622,300.00	215,205,885.00	17,416,415.00	92.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,337,100.00	48,183,473.00	(16,846,373.00)	153.76
210104	Урамшуулал	20,321,800.00	62,999,241.00	(42,677,441.00)	310.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,456,400.00	83,456,400.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	59,214,300.00	59,214,300.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,060,500.00	6,060,500.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,030,300.00	3,030,300.00	-	100.00

Баянхонгор аймгийн Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	3,030,300.00	3,030,300.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,121,000.00	12,121,000.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,926,100.00	78,925,145.72	954.28	100.00
210301	Гэрэл, цахилгаан	4,445,100.00	3,203,194.17	1,241,905.83	72.06
210302	Түлш, халаалт	71,910,900.00	73,973,897.55	(2,062,997.55)	102.87
210303	Цэвэр, бохир ус	2,570,100.00	1,748,054.00	822,046.00	68.02
2104	Хангамж, бараа материалын зардал	14,219,200.00	14,219,200.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	1,450,200.00	2,337,700.00	(887,500.00)	161.20
210402	Тээвэр, шатахуун	10,961,700.00	9,736,162.00	1,225,538.00	88.82
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,100.00	576,600.00	(376,500.00)	288.16
210404	Ном, хэвлэл	74,400.00	38,000.00	36,400.00	51.08
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	884,000.00	650,000.00	234,000.00	73.53
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	648,800.00	880,738.00	(231,938.00)	135.75
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,615,800.00	9,611,300.00	4,500.00	99.95
210604	Урсгал засвар	9,615,800.00	9,611,300.00	4,500.00	99.95
2107	Томилолт, зочны зардал	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,807,300.00	16,804,168.00	3,132.00	99.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,968,100.00	7,967,688.00	412.00	99.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,839,200.00	8,836,480.00	2,720.00	99.97
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,853,317,200.00	6,835,926,389.00	17,390,811.00	99.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,853,317,200.00	6,835,926,389.00	17,390,811.00	99.75
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,519,141,000.00	1,511,704,613.00	7,436,387.00	99.51
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,282,598,900.00	5,272,671,020.00	9,927,880.00	99.81
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	51,577,300.00	51,550,756.00	26,544.00	99.95
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,710,692,600.00	7,693,293,202.72	17,399,397.28	99.77
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,710,692,600.00	7,693,293,202.72	17,399,397.28	99.77
122005	Улсын төсвөөс санхүүжих	7,710,692,600.00	7,693,293,202.72	17,399,397.28	99.77

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	86,655,572.00	103,841,576.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	86,655,572.00	103,841,576.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	86,655,572.00	103,809,328.50

Баянхонгор аймгийн Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	37,195,454.69
210102	Нэмэгдэл	-	37,195,454.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	3,356,857.81
210201	Тэтгэврийн даатгал	-	3,356,857.81
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	86,655,572.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	86,655,572.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	63,257,016.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	63,257,016.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	32,248.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	32,248.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	32,248.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	86,655,572.00	103,841,576.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	86,655,572.00	103,841,576.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,109,010.00	50,349,312.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	36,785,312.00	53,492,264.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	761,250.00	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Боловсролын газар нь "Монгол Улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлж хүүхэд бүр амжилттай суралцах тэгш боломжийг олгосон боловсролын үйлчилгээ үзүүлж, гүйцэтгэлд суурилсан төсвийн шинэчлэлийг хэрэгжүүлэх" зорилго дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй БШУЯ-аас бэлтгэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлог тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 134,284.3 мянган төгрөг буюу 13.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	182,000.2	73,048.5	(108,951.7)
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	1,109.7	4,917.5	3,807.9
Урьдчилгаа	1.6	-	(1.6)
Бараа материал	180,888.9	68,131.0	(112,758.0)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	817,104.7	791,772.1	(25,332.7)
Үндсэн хөрөнгө	994,628.4	1,024,293.6	29,665.1
Хуримтлагдсан элэгдэл	(177,523.7)	(232,521.5)	(54,997.8)
Нийт хөрөнгө	999,104.9	864,820.6	(134,284.3)
Өр төлбөр	350.5	-	(350.5)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	998,754.3	864,820.6	(133,933.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	999,104.9	864,820.6	(134,284.3)

Авлагын дансны үлдэгдэл 4,917.5 мянган төгрөг байгаа нь Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 4,865.0 төгрөг бөгөөд оны эхэнд 1,109.7 мянган төгрөгийн авлагатай барагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 68,131.0 мянган төгрөг болж 112,758.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Төсвийн худалдан авалтаар 33,549.0 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 146,307.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсны байна. Харин сурах бичгийн орлого 79,697.0 мянган төгрөгийн орлого зарлагыг балансаас гадуур бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,024,293.6 мянган төгрөг болж 29,665.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн худалдан авалтаар 6,499.9 мянга, Боловсролын ерөнхий газраас 23,165.2 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж шилжин ирснийг хүлээн авч орлогод бүртгэсэн байна.

Тайлант оны эхэнд 350.5 мянган төгрөгийн өр төлбөр байсныг барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 864,820.6 мянган төгрөг болж 133,933.8 мянган төгрөгөөр буурсан нь үеийн үр дүнгээр хуримтлагдсан 133,933.8 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,085,275.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 176,322.3 мянган төгрөгөөр бууруулж 908,952.7 мянган төгрөгөөр баталсан байна. Харин аймгийн хэмжээний багш албан хаагчдын Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 1,519,141.0 мянган төгрөг төсөвлөж гүйцэтгэлээр 1,511,704.6 мянган төгрөг, Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 5,282,598.9 мянган төгрөг төсөвлөж 5,272,671.0 мянган төгрөгийн гүйцэтгэл гарсан нь Боловсролын газрын төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэгдсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 7,710,692.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 7,693,293.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 7,693,293.2 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь тэтгэмж урамшууллын зардалд туссан 17,399.4 мянган төгрөгийг зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/ мянган төгрөгөөр/		
д/д		Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	6,853,317.2	6,835,926.4	(17,390.8)	99.7
2	80101	Үндсэн үйл ажиллагааны орлого	857,375.4	856,766.8	(608.6)	99.9
		НИЙТ	7,710,692.6	7,692,693.2	(17,999.4)	99.8

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Боловсролын ерөнхий газраас сургалт зохион байгуулах зардалд 37,492.3 мянган төгрөг, ЭЕШ-ийн багшийн хөгжил зохион байгуулалтын зардалд 16,000.0 мянга, албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдэлтэй холбогдох зардалд 40,652.3 мянга, олимпиадын санхүүжилтэд 4,997.0 мянга, багш нарын 58 дахь удаагийн арга хэмжээний зардалд 5,000.0 мянган төгрөг нийт 103,841.6 мянган төгрөг төвлөрч 103,809.3 мянган төгрөгийг зарцуулж 32.2 мянган төгрөгийг оны эцэст төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллагад худалдан авалтын төлөвлөгөө байхгүй, худалдан авах ажиллагаа зохион байгуулах урсгал зардал байхгүй байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Боловсролын газар нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 7,710,692.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 77,106.9 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 50,119.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй бөгөөд тогтмол зардлыг 100 хувь зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж үзэхэд Баянхонгор аймгийн Боловсролын газар Дараа жилийн төсвийн төсөл, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож байршуулсан байгаа нь нийт 171 мэдээллийн 1,2 хувь буюу материаллаг бус байгаа тул зөрчлөөр бүртгээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж аудитаар 19,140.4 мянган төгрөгийн 2 албан шаардлага, өмч хөрөнгөтэй холбоотой 1 зөвлөмж өгснийг биелүүлсэн талаар тус байгууллагаас 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 230 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	19,140.4	2	19,140.4	100%
Зөвлөмж	1	3,561.0	1	3,561.0	100%
Нийт дүн	3	22,701.4	3	22,701.4	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Нийгмийн даатгалын шимтгэлд нийт 6,242.4 мянган төгрөгийг илүү төлсөн байхад 4,865.0 мянган төгрөгийг авлагаар тусгаж 1,377.5 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд дутуу тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-т заасан “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т заасан “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагаар дутуу тусгасан 1,377.5 мянган төгрөгийг Нийгмийн даатгалын илүү төлөлтийг суутган тооцож аймгийн Боловсролын газрын төсвөөс орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Дээрх шийдвэрийн хэрэгжилтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийгмийн даатгалын шимтгэлд нийт 6,242.4 мянган төгрөгийг илүү төлсөн байхад 4,865.0 мянган төгрөгийг авлагаар тусгаж 1,377.5 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд дутуу тусгасан байна.	1	1,377.5	1	1,377.5				
Нийт дүн	1	1,377.5	1	1,377.5				

-----oOo-----